



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/97.

Мандалговь

Түргэвчилсэн оношлуур нийлүүлэх ажлыг
шуурхай зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.7 дахь заалтыг үндэслэн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйл 32.1.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 29 дүгээр тушаал, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтээр тархаад буй Ковид-19 цар тахлын дэгдэлт Монгол улс тэр дундаа Улаанбаатар хотод эрс нэмэгдэж байгаа тул аймагт орж ирж байгаа хүн бүрээс түргэвчилсэн оношлуураар ковидын шинжилгээ авах шаардлагатай байгаа тул Эрүүл мэндийн яамны БНСУ-ын SD BIOSENSOR, INC үйлдвэртэй байгуулсан гэрээний дагуу Эрүүл мэндийн яамаар дамжуулан 1500 ширхэг оношлуур нийлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулсугай.

2. 1500 ширхэг түргэвчилсэн оношлуурын 21,246,452 (хорин нэгэн сая хоёр зуун дөчин зургаан мянга дөрвөн зуун тавин хоёр) төгрөгийн зардлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Гамшгийн эрсдэлийг бууруулах нөөц" ажлын батлагдсан зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Алтантөгс) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210299